

“ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ, ТӨЛБӨРИЙН АРГА, ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2024.10.01

Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль хуулиудад УИХ-аас 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2021 оноос эхлэн төр төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэг болох “Эрүүл мэндийн тухай хуулийн 24.6.10-т заасан өрх, сум, тосгоны хэмжээнд үзүүлэх зарим тусламж, үйлчилгээ”-г Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан чанар, үр дүн гүйцэтгэлд үндэслэн худалдан авахаар хуульчилсан. Монгол Улсын Төсвийн тухай хуулиар эрүүл мэнд, боловсрол, соёлын үйлчилгээг тусгай зориулалтын шилжүүлгээр орон нутгийн төсөвт шилжүүлж санхүүжүүлдэг байсан тогтолцоог 2022 оноос өөрчилсөн бөгөөд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр болсон. Эдгээр өөрчлөлтүүдийн хүрээнд ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоол, 2023 оны 06 дугаар, 2024 оны 05 дугаар тогтоолуудыг батлуулан хэрэгжүүлж байна.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээг оновчтой, хүртээмжтэй, үр дүнд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийг хэрэгжүүлж буй багц, төлбөрийн арга, журам, зохицуулалтад Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсөвийн хүрээнд зарим нэг бодлогын тохируулга хийх замаар ЭМДҮЗ-ийн 2024 оны 05 дугаар тогтоолыг шинэчлэн батлуулах хэрэгцээ үүссэн.

Энэхүү тогтоолыг шинэчлэн баталснаар өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн ажилчдын үндсэн цалинг нэмэгдүүлж, алслагдсан хүн амд анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлж буй эмч, мэргэжилтнүүдээ тогтвор суурьшилтай ажиллуулах, ард иргэдэд тулгамдаж буй анхан шатны нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, цаашилбал лавлагаа шатлалын эмнэлэгт илгээж буй шалтгааныг бууруулахад эерэг үр дүн үзүүлнэ гэж үзэж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР